



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/178/СТА-ТШЗ

Баянхонгор
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
Шилэн дансны цахим санд “Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар” /үлирал бүр/ байршуулах мэдээллийг 1,3-р улиралд, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар” /тухай бүр/ мэдээллийг 1,2,4-р сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/ мэдээллийг 1,3-9-р сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ мэдээллийг 1-9 сард хугацаа хоцроон мэдээлсэн байна.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Б4101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 12 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ч.ОЛДДОГҮЙ
ТАНАА

2020.02.10 № 1/60

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020018

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Ч.Олддоггүй Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд хувийн онцлог, хүсэл сонирхлоороо өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадвар, дадал, төлөвшлийг эзэмшихэд чиглэгдсэн арга барилыг эзэмшсэн багш ажилтантай “Сайн туршлага”-ыг түгээгч байгууллага болно” оршино.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамран сургах тойрог болох Баянхонгор сумын Эрдэнэмандал, Дуурсах багуудын 2-5 насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үндсэн чиг үүрэгтэй. Хамран сургах тойргийн хүүхдүүдийг үндсэн болон хувилбарт сургалтад хамруулан сургуулийн өмнөх боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 267228.2 мянган төгрөгөөс тооцон 5344.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 382136.8 мянган төгрөгөөр тооцон 7642,7 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7151,4 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/		
		Эхийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,549.56	52,914.75	5,365.2
35	БАРАА МАТЕРИАЛ	47,549.56	52,914.75	5,365.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	511,421.74	498,905.12	-12,516.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	511,421.74	498,905.12	-12,516.6
39208	Хуримтлагдсан элэгдэл	22,108.88	23,745.07	1,636.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	558,971.31	551,819.87	-7,151.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	558,971.31	551,819.87	-7,151.4
51	Засгийн газрын хувь оролцоо	558,971.31	551,819.87	-7,151.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	558,971.31	551,819.87	-7,151.4

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 5365,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цэцэрлэгийн эцэг эхийн хандиваар үнэ төлбөргүй 768,5 мянга төгрөгийн бараа материал орлого авсан, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 4245,3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 8291,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь 2019 онд төсвийн хөрөнгөөр 5021,7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, эцэг эхийн хандиваар 6608,9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн, харин 3339,3 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 129 дугаар тогтоолыг үндэслэн актлан данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд 23745,0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон ба хуримтлагдсан элэгдлийн дүн 57054,1 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 551819,8 мянган төгрөг болж 7151,4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасах илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор сумын 12-р цэцэрлэг нь төвлөрүүлэх орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрт зориулан 80802 /ажил олгогчоос оруулах тэтгэмж/, 81807 /цэцэрлэгийн хүүхдийн хоол/, 81831 /ээлжийн бүлэгт хамруулах/, 81834 /боловсролын стандарт сургалтыг хангах/, 81835 /сургалтын хэвийн үйл ажиллагааг

хангах/-д зориулалттай 363562,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 319569,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 43993,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 363562,8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авчээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 363111,4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс 363562,8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 451,3 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарт олгох 5 жилийн мөнгөн урамшуулал санхүүжилтийн 4045,2 мянган төгрөг БСУГ-аас нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн нь олгогдсон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэлийг үнэлж гүйцэтгэх үе шатанд 23 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7446,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

1. Цалингийн зардлаас байгууллагын хөдөлмөрийн аварга, оны шилдэг багш, бүтээлч ажилтан шалгаруулан эрхлэгчийн 2019.12.18-ны өдрийн Б/68-Б/70 тоот тушаалуудаар ажилтанд 650,0 мянган төгрөгийн шагналыг олгохдоо нэг удаагийн тэтгэмжийн зардлаас гаргахгүй, хэмнэгдсэн цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Хоолны зардлын төсвөөс гүйцэтгэлээр нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагад олголгүй хэмнэгдсэн зардлыг шилжүүлэн тайлант хугацааны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, нөөцөлж, хүнсний материалын үлдэгдлээр 6796,2 мянган төгрөг тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх", "Тохиолдсон байх: аж ахуй нэгж байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн 7446,2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож 2020 оны 03 дугаар сарын 25-ны дотор төсөвт төвлөрүүлэх.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	145	4	2

Шилэн дансны цахим санд “Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар” /улирал бүр/ байршуулах мэдээллийг 1,3-р улиралд, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар” /тухай бүр/ мэдээллийг 1,2,4-р сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/ мэдээллийг 1,3-9-р сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ мэдээллийг 1-9 сард хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,549,563.33	52,914,749.45
35	БАРАА МАТЕРИАЛ	47,549,563.33	52,914,749.45
351	Түүхий эд материал	33,490,788.00	34,729,888.00
35110	Тусгай зориулалттай материал	33,490,788.00	34,729,888.00
354	Хангамжийн материал	14,058,775.33	18,184,861.45
35410	Бичиг хэргийн материал	785,380.00	512,400.00
35420	Аж ахуйн материал	6,768,501.00	6,165,701.00
35460	Хүнсний материал	2,550,894.33	6,796,260.45
35470	Бусад хангамжийн материал	3,954,000.00	4,710,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	511,421,744.85	498,905,118.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	511,421,744.85	498,905,118.90
392	Биет хөрөнгө	419,905,578.02	407,530,118.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	401,488,618.99	401,488,618.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,181,749.74	-18,798,210.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,779,869.55	30,633,453.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,972,030.31	-25,441,794.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,486,219.45	29,183,269.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,463,613.60	-12,044,082.40
39217	Ном	768,263.68	2,508,863.68
393	Биет бус хөрөнгө	91,516,166.83	91,375,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-628,833.17	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	91,375,000.00	91,375,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	558,971,308.18	551,819,868.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	558,971,308.18	551,819,868.35
51	Засгийн газрын хувь оролцоо	558,971,308.18	551,819,868.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,375,000.00	91,375,000.00
51101	Өмч: - төрийн	91,375,000.00	91,375,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	457,796,835.06	450,645,395.23
51210	Өмнөх үеийн үр дүн	457,796,835.06	457,796,835.06
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-7,151,439.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,799,473.12	9,799,473.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	558,971,308.18	551,819,868.35

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	304,644,919.80	374,985,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	7,377,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	7,377,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	7,377,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	7,377,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,530,819.80	48,038,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,114,100.00	319,569,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,530,819.80	4,045,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,530,819.80	4,045,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	43,993,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	43,993,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	320,585,886.59	381,734,681.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,585,886.59	381,734,681.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,633,925.05	377,102,624.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,185,651.00	228,765,714.00
210101	Үндсэн цалин	168,875,675.00	208,733,686.00
210104	Урамшуулал	12,309,976.00	20,032,028.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,236,601.00	28,650,794.00
210201	Тэтгэврийн даатгал	15,166,853.00	19,717,087.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,895,855.00	2,319,658.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,453,326.00	1,830,126.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,235.00	434,902.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,382,332.00	4,349,021.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,669,489.00	39,548,730.00
210301	Гэрэл, цахилгаан	4,009,663.00	5,166,082.00
210302	Түлш, халаалт	24,290,996.00	24,452,778.00
210303	Цэвэр, бохир ус	9,368,830.00	9,929,870.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,926,516.26	3,891,795.06
210401	Бичиг хэрэг	404,280.00	168,980.00
210402	Тээвэр, шатахуун	217,000.00	99,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	667,217.26	806,515.06
210404	Ном, хэвлэл	00.00	15,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	877,219.00	929,400.00
210408	Бараа материал акталсны зардал	760,800.00	1,692,700.00

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2105	Нормативт зардал	47,025,990.17	45,116,333.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,300.00	62,900.00
210502	Хоол, хүнс	46,648,790.17	44,330,433.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	313,900.00	723,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,379,800.00	3,377,900.00
210604	Урсгал засвар	1,379,800.00	3,377,900.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,712,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,200.00	808,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,032,200.00	558,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,177,677.62	25,230,857.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,941,800.00	322,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	127,000.00	1,163,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,108,877.62	23,745,067.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,951,961.54	4,632,056.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	4,180,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	135,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,045,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,951,961.54	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,951,961.54	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	70.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	70.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	451,286.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	451,286.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-15,940,966.79	-6,749,281.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	257,906,529.93	402,158.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,720.00	402,158.75
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	257,867,809.93	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-257,906,529.93	-402,158.75
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-273,847,496.72	-7,151,439.83

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	304,644,919.80	367,608,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,644,919.80	367,608,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,114,100.00	319,569,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,530,819.80	4,045,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,530,819.80	4,045,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	43,993,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	43,993,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,644,919.80	367,608,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,644,919.80	367,608,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,692,958.26	362,975,943.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,654,831.20	228,765,714.00
210101	Үндсэн цалин	159,868,131.20	191,032,414.00
210102	Нэмэгдэл	7,568,300.00	19,376,000.00
210104	Урамшуулал	12,218,400.00	18,357,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,236,601.00	28,650,794.00
210201	Тэтгэврийн даатгал	15,166,853.00	19,823,471.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,895,855.00	2,246,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,453,326.00	1,797,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,235.00	434,902.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,382,332.00	4,349,021.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,669,489.00	39,548,730.00
210301	Гэрэл, цахилгаан	4,009,663.00	5,166,082.00
210302	Түлш, халаалт	24,290,996.00	27,946,032.00
210303	Цэвэр, бохир ус	9,368,830.00	6,436,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,833,617.26	2,778,715.06
210401	Бичиг хэрэг	406,500.00	236,500.00
210402	Тээвэр, шатахуун	217,000.00	99,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	667,217.26	806,515.06
210404	Ном, хэвлэл	10,000.00	296,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,532,900.00	1,159,800.00
2105	Нормативт зардал	49,472,800.00	50,809,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,300.00	62,900.00
210502	Хоол, хүнс	48,055,900.00	48,575,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,353,600.00	2,171,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,691,700.00	8,702,400.00
210602	Тавилга	00.00	4,050,000.00
210604	Урсгал засвар	3,691,700.00	4,652,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,712,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	112,000.00

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,200.00	808,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,032,200.00	558,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,101,719.80	1,199,290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,986,719.80	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	1,199,290.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,951,961.54	4,632,056.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	4,180,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,045,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	135,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,951,961.54	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,951,961.54	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	70.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	70.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	451,286.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	451,286.94
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	457,796,835.06	558,971,308.18
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	457,796,835.06	558,971,308.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	457,796,835.06	558,971,308.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,151,439.83	-7,151,439.83
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	450,645,395.23	551,819,868.35

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	363,562,800.00	363,111,443.06	451,356.94	99.88
УРСГАЛ ЗАРДАЛ	363,562,800.00	363,111,443.06	451,356.94	99.88
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,427,300.00	362,975,943.06	451,356.94	99.88
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,215,700.00	228,765,714.00	449,986.00	99.80
Үндсэн цалин	191,482,400.00	191,032,414.00	449,986.00	99.76
Нэмэгдэл	19,376,000.00	19,376,000.00	0.00	100.00
Урамшуулал	18,357,300.00	18,357,300.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,650,800.00	28,650,794.00	6.00	100.00
Тэтгэврийн даатгал	19,833,200.00	19,823,471.00	9,729.00	99.95
Тэтгэмжийн даатгал	2,246,300.00	2,246,300.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	1,797,100.00	1,797,100.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	449,200.00	434,902.00	14,298.00	96.82
Эрүүл мэндийн даатгал	4,325,000.00	4,349,021.00	-24,021.00	100.56
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,548,800.00	39,548,730.00	70.00	100.00
Гэрэл, цахилгаан	3,613,600.00	5,166,082.00	-1,552,482.00	142.96
Түлш, халаалт	27,946,100.00	27,946,032.00	68.00	100.00
Цэвэр, бохир ус	7,989,100.00	6,436,616.00	1,552,484.00	80.57
Хангамж, бараа материалын зардал	2,779,600.00	2,778,715.06	884.94	99.97
Бичиг хэрэг	122,000.00	236,500.00	-114,500.00	193.85
Тээвэр, шатахуун	100,000.00	99,200.00	800.00	99.20
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,406,200.00	806,515.06	599,684.94	57.35
Ном, хэвлэл	67,800.00	296,700.00	-228,900.00	437.61
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	903,600.00	1,159,800.00	-256,200.00	128.35
Нормативт зардал	50,810,200.00	50,809,800.00	400.00	100.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,300.00	62,900.00	400.00	99.37
Хоол, хүнс	48,575,800.00	48,575,800.00	0.00	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,171,100.00	2,171,100.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	8,702,400.00	8,702,400.00	0.00	100.00
Тавилга	4,050,000.00	4,050,000.00	0.00	100.00
Урсгал засвар	4,652,400.00	4,652,400.00	0.00	100.00
Томиллолт, зочны зардал	1,712,000.00	1,712,000.00	0.00	100.00
Гадаад албан томиллолт	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00
Дотоод албан томиллолт	112,000.00	112,000.00	0.00	100.00

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Батлагдсан толовлогөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	808,500.00	808,500.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	558,500.00	558,500.00	0.00	100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1199300.00	1199290.00	10.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,199,300.00	1,199,290.00	10.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135500.00	135500.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	135,500.00	135,500.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	135,500.00	135,500.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	363,562,800.00	363,111,443.06	451,356.94	99.88
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	319,569,400.00	319,118,043.06	451,356.94	99.86
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319,569,400.00	319,118,043.06	451,356.94	99.86
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,993,400.00	43,993,400.00	0.00	100.00
Орон нутгийн төсвөөс	43,993,400.00	43,993,400.00	0.00	100.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.00
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	188.00	188.00	0.00	100.00
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	188.00	188.00	0.00	100.00
Төрийн өмчит ЕБС	188.00	188.00	0.00	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	0.00	100.00
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ГҮБД)	15.00	15.00	0.00	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ГҮ)	11.00	11.00	0.00	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1530819.80	4,045,200.00
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1530819.80	4,045,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1530819.80	4,045,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1530819.80	4,045,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1530819.80	4,045,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1530819.80	4045200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,045,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1530819.80	4,045,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

П.Амаржаргал

П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.Цээням

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

